

Сэтгэл ханамжийн судалгаа 2026 оны 3-р улирлын тайлан

Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ болон эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 2024 онд Улсын хоёрдугаар төв эмнэлгээс дахин боловсруулсан асуумжийн дагуу авсан. Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 13 асуулттай. Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж нь 14 асуулттай. Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн асуумж нь 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авлаа.

2026 оны 3-р улиралд “Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 354 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-113 үйлчлүүлэгч, хоёрдугаар улиралд-126 үйлчлүүлэгч, 3-р улиралд-115 үйлчлүүлэгч тус тус хамрагдсан байна.

2026 оны 3-р улиралд “Хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд” нийт 320 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан. Нэгдүгээр улиралд-99 үйлчлүүлэгч, хоёрдугаар улиралд-111, 3-р улиралд-110 үйлчлүүлэгч тус тус хамрагдсан байна.

2026 оны 3-р улиралд Амбулаторийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 89%(маш сайн, сайн), хэвтэн эмчлүүлэгчдийн ерөнхий сэтгэл ханамжийн хувь 96.5%(маш сайн, сайн) байна. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны мөрөөр ажил сайжруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

2026 онд “Эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд” давхардсан тоогоор 356 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан байна. Нэгдүгээр улиралд-110, хоёрдугаар улиралд-131, 3-р улиралд-115 эмч, эмнэлгийн ажилчид тус тус хамрагдсан байна. 2026 оны 3-р улиралд эмнэлгийн ажилтны Ерөнхий сэтгэл ханамжийн хувь 65% (маш сайн, сайн) байна.

Эмч, эмнэлгийн ажилчид сэтгэл ханамжийн судалгааг хангалтгүй бөглөж байгаа нь ажилтны хэн хэрхэн бөглөсөн нь харагдана гэх шалтгаанаар нийт ажилчдын 30-40% нь судалгааг бөглөж байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЭМТҮЧАБЭ-ИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,

ЭРСДЭЛ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

Б.НОМИН

ХЯНАСАН:

ЭМТҮЧАБЭ-ИЙН АЛБАНЫ ДАРГА

З.АРЪЯАСҮРЭН